



“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

“Ажлын байрны ашиглалтын зааварчилгаа” батлах тухай



Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Таван толгой түлш” ХХК-ийн Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн ажлын байрны онцлогт нийцсэн “Тоног төхөөрөмжийн засварчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 1 дүгээр хавсралтаар, “Тоноглолын ашиглалтын болон засварын ажилтны аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа”-г 2 дугаар хавсралтаар, “Наряд олгогч, ажлын удирдагч, эзлжийн ахлах ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 3 дугаар хавсралтаар, “Гал тогооны ажилтны ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 4 дүгээр хавсралтаар, “Өндөрт ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 5 дугаар хавсралтаар, “Цахилгаанчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 6 дугаар хавсралтаар, “Оосорлогч-дохиочны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 7 дугаар “Бага температурт задгай талбайд ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 8 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан зааварчилгааг үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Үйлдвэрлэлийн албаны дарга, Ерөнхий инженер, Ерөнхий механик, Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн хэсэгт тус тус үүрэг болгосугай.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ




М. ГАНБААТАР

	Бага температурт задгай талбайд ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-05	
		Хувилбар: 1	
		Тушаал № А/43	

БАГА ТЕМПЕРАТУРТ ЗАДГАЙ ТАЛБАЙД АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:		М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:		Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

	Бага температурт задгай талбайд ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-05	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2020 онсар өдөр
		Тушаал №	

БАГА ТЕМПЕРАТУРТ ЗАДГАЙ ТАЛБАЙД АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../	Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

Бага температурт задгай талбайд ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-05
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

Бага температурт задгай талбайд ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-05
	Хувилбар: 1

Агуулга

Нэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага	4
Хоёр. Ажил эхлэхийн өмнөх үеийн аюулгүйн шаардлага	4
Гурав. Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	4
Дөрөв. Ажил дууссаны дараах үеийн аюулгүйн шаардлага	5

Бага температурт задгай талбайд ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-05
	Хувилбар: 1

НЭГ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН

ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 1.1. Бага температурт задгай талбайд ажиллахад ажилтан хөлдөхөөс хамгаалах аюулгүй ажиллагааны шаардлагыг биелүүлж ажиллах шаардлагатай.
- 1.2. Бага температурт задгай талбайд ажиллах үед хүйтэнд ажиллах хугацаа, дулаан байранд орж завсарлах хугацааны дэглэмийг чанд баримтална.

ХОЁР. АЖИЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨХ АЮУЛГҮЙН ШААРДЛАГА

- 2.1. Хувийн хамгаалах хэрэгслийн дулаан хадгалах чадвар, биеийн идэвхтэй байдал, тухайн цаг уурын нөхцөлийг тооцон хүйтэнд байх хугацааг тодорхойлно.
- 2.2. Ажлын байрны үзлэгээр:
 - Орц, гарц, зам чөлөөтэй эсэх;
 - Ажлын талбай хангалттай гэрэлтүүлэгтэй эсэх;
 - Цахилгааны утас бүрэн бүтэн, өлгөөтэй эсэх;
 - Тоног төхөөрөмжийн удирдлагын болон гүйдлийн хаалт найдвартай эсэх;
 - Газардуулагч байгаа эсэх, найдвартай эсэх;
 - Тоног төхөөрөмжийн хөдлөх хэсгийн найдвартай бэхэлгээ, зөв суурилуулалт, найдвартай ажиллагаа болон бүрэн бүтэн байгаа эсэх;
 - Тоног төхөөрөмжийн дотор болон эргэн тойронд нь гадны биет байгаа эсэх;
 - Эд зүйлс, тоноглол, багаж хэрэгсэл хэвийн ажиллагаатай эсэх;
 - Шалгах, хэмжих хэрэгсэл байгаа эсэх, хэвийн ажиллагаатай эсэх;
 - Шалны байдал (тэгш бус, халтиргаатай, хагархай г.м.)

ГУРАВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ

ЗААВАРЧИЛГАА

- 3.1. Ажлын ээлжинд нэг удаагийн гадаа хүйтэнд ажиллах хугацааг хэтрүүлж болохгүй.
- 3.2. Гадаа засварлагын хугацааг -10°C хүртэл 10 минут, -10°C -ээс бага температурт 5 минутаас хэтрүүлж болохгүй.
- 3.3. Ээлжийн үргэлжлэх хугацаанд 4 цаг тутамд халаалттай байранд 10 минутаас ихгүй хугацаанд амарч дулаацахыг зөвшөөрнө.
- 3.4. Дулаацах байрны температур 21°C - 25°C байна. дулаацах байранд гар, хөл дулаацуулах төхөөрөмж байх ба түүний температур 35°C - 40°C хэмтэй байна.
- 3.5. Цайны цаг болон дулаацах байранд байх үедээ халуун зүйл уух ба цайны цагаар халуун хоол унд идсэнээс хойш 10 минутын дараа гадаа ажиллана.
- 3.6. Гадаа температур -40°C хэмээс бага үед нүүр, амьсгалын замын хамгаалах хэрэгсэл ашиглана.

Бага температурт задгай талбайд ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-АА-05
	Хувилбар: 1

- 3.7. Гадаа температур -30°C хэмээс бага үед биеийн хүчний ажил гүйцэтгэхийг хориглоно.
- 3.8. Ажлын байранд дулаацах болон бусад зорилгоор ил гал гаргахыг хориглоно.
- 3.9. Ажилтны эд эрхтэн хөлдсөн тохиолдолд осолдогчийг дулаан байранд оруулж, хувцсыг тайлна. Осолдогчид бүлээн цай өгч биеийн температурыг аажмаар өсгөж дулаацуулж хөлдсөн хэсгийн цусны эргэлтийг сайжруулна. Эмчид хандана.

ДӨРӨВ. АЖИЛ ДУУССАНЫ ДАРААХ АЮУЛГҮЙН ШААРДЛАГА

- 4.1. Ажлын явцад гарсан аливаа доголдлын талаар шууд удирдлагад мэдэгдэнэ.